

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Дэндэвийн Ишсамбуу	Дугаар	L201
Оршин суугаа аймаг	Дорноговь	Оршин суугаа сум	Даланжаргалан сум
Төрсөн газар	Сүмбэр	Төрсөн он	1917
Ажил мэргэжил	Өндөр настан		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Жанжин Чойр хийд	Сүм хийдийн дугаар	ГСЧР 147
Одоогийн сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 7-р сарын 20	Ярилцлага авсан хүн	Ц.Гантулга



Говь-Сүмбэр аймгийн Сүмбэр сумын Зүүн Чойрын хийд

.За Ишсамбуу гуай та аль хийдэд шавилан сууж байсан бэ?

Ишсамбуу:Зүүн Чойрын хийдэд шавилан сууж байсан

Гантулга:Хэдэн наснаасаа хэдэн нас хүртлээ сууж байсан бэ?

Ишсамбуу:7 настайдаа очиж суугаад 17-той гарч байсан

Гантулга: Зүүн Жанжин Чойрыг одоо өөрөө юу гэж нэрлэдэг вэ?

Ишсамбуу: Зүүн Чойр л гэж нэрлэдэг юмаа

Гантулга: Хэдий үед ямар хүн байгуулсан хийд вэ?

Ишсамбуу: За мэдэхгүй ээ, Тэрийг сайн мэдэхгүй

Гантулга: Хуучин засаг захиргааныхаа нэгжээр бол аль хошуу нутгийн хийд вэ?

Ишсамбуу: Боржигон Цэцэн вангийн хошууны Боржигон хошууны Зүүн Чойр оо

Гантулга: Одоо энэ Зүүн Чойрын хийдийн ойр орчимд байгаа ойролцоо газар усны нэрийг нэрлэвэл? Одоо Чойрын хийдийн эргэн тойронд нь байгаа..?

Ишсамбуу:Богд уул гэж бий, хоёр Богд уул гэж бий. Сансар гэж бий.Цагаан рашаан гэж бий

Гантулга: Эргэн тойронд нь ...Яг байгаа газрыг нь юу гэж нэрлэдэг байсан юм бол?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ишсамбуу: Марзын хоолой гэдэг юм

Гантулга: Аан Марзын хоолой гэдэг газар.Энэ Боржигон Цэцэн вангийн хошууны сүүлийн ноён нь ямар хүн байсан юм бэ?

Ишсамбуу:Ээ дээ тэр чинь ямар хүн байлаа...

Гантулга: Гомбосүрэн дарга гэж нэг хүн байсан .Тэр мөн болов үү?

Ишсамбуу: Ээ тийм тийм .Мөн

Гантулга: Ойрхон одоо тахидаг байсан рашаан уул овоо?

Ишсамбуу:Аа тэр бол уул эд нарыг тахидаг байсан юм аа.Тэр хоёр уул эд нарыг...

Гантулга: Хоёр уулаа юу?Өөр бас нэг Таван уул тахидаг байсан гэсэн ?

Ишсамбуу:Тэр Таван уул гэдэг чинь Сансар уулыг тэгдэг байсан юмаа

Гантулга:Тэр хоёр Богд?

Ишсамбуу: Тийм, Сансар уул

Гантулга:Цагаан...?

Ишсамбуу: Тийм Цагаан...Цагаан уул

Гантулга: Тэгээд хойд уул , дунд уул гээд байсан , тиймээ?

Ишсамбуу: Тиймээ, байсан

Гантулга: Ер нь ойрхон , Чойрын хийдтэй ойрхон ямар сүм хийд байв?Баруун Чойр байна үү?

Ишсамбуу: Баруун Чойр байсан

Гантулга: Ойрхон уу хоорондоо?

Ишсабуу: Одоо Жинлүү гэж бий, Заргын жас гэж бий , Улаан устны жас гэж бий, Хоолтын жас.Чойрын жас, Шинэ Бүрдний жас, Далиусүргийн жас энэ тэр гэж бий л дээ

Гантулга: Эд нар дээр та өөрөө очиж байсан юмуу, одоо сайн мэдэх тэр нь тийм шүтээн сахиустай, тэдэн ламтай, тийм тийм хурал хурдаг байсан, тэдэн дуган дацантай байсан гээд мэддэгээсээ яривал?

Ишсамбуу:Хээрийн зуу гэдэг жас хүрж байсан.Хоёр ч билүү тийм дацан хуралтай.Тийм газар байсан

Гантулга: Гол шүтээн нь ?

Ишсамбуу:Гол шүтээн нь Зуугийн шүтээн гэж байсан.Рэгзэв гэж нэрлэдэг шүтээн байсан.Манай тэр Боржигоны юуны юунд гурван их Тоо Чойр гэдэг ардын суварга...За тэр Занданчойр биш ээ

Гантулга: Заргын?

Ишсамбуу: Заргын жас лам нар нь Хээрийн зуу энэ хийдийг их тоотой гэдэг байсан

Гантулга: Заргын дээр нь юу байсан юм , энэ заргын жас дээр нь ?

Ишсамбуу: Заргын жас дээр нь хурал байсан юм аа .Зуны хурал байсан

Гантулга: Тэгээд Рэгзэв гэдэг нь бол суварга байсан юм үү?

Ишсамбуу: Үгүй ээ.Шүтээн

Гантулга: Шүтээн?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ишсамбуу: Тийм

Гантулга: Тэр Заргын жасын гол шүтээн нь Рэгзэв үү?

Ишсамбуу: Тийм

Гантулга: Ямар шүтээнтэй байсан юм?

Ишсамбуу: Чойрын сахиус байсан юм гэнэ лээ.

Гантулга: Ном хэр хурах вэ, аа нөгөө Нандиндорж?

Ишсамбуу: Тийм

Гантулга: Заргын хийдийн?

Ишсамбуу: Тийм

Гантулга: Аа Чойрын хийд дээр иргэд ирж их эргэл мөргөл хийдэг байсан үү?

Ишсамбуу: Аа тийм. Лам л их ирдэг байсан юм

Гантулга: Лам нар нь тийм тусгай дуган дацантай байсан уу?

Ишсамбуу: Аа нэг жаахан гэртэй. Нэг жаахан гэртэй тийм газар байдаг байсан юм аа

Гантулга: Бас мөргөлчид ирнэ?

Ишсамбуу: Ламын жас гэж байдаг байсан юмаа

Гантулга: Бас ламын жас гэж байсан юм уу?

Ишсамбуу: Тийм, ламын жас гэж. Хойдхаан...

Гантулга: Тэр Эрээнд байдаг байсан гээд байсан үү?

Ишсамбуу: Биш юмаа

Гантулга: Ламын жас дэр нь яг юу юу байдаг байсан? Эргэл мөргөлийн газар байсан үү?

Ишсамбуу: Тийм зуны хурал байсан юм

Гантулга: Аа мөн мөн

Ишсамбуу: Тэр ламын тэнд байсан юм. Тэр чинь Чингэний эзэн гэж одоо Зүүн Чойрын лам биднийг л хардаг,, лам биднийг яавал л аянчин хийсэн ч лам бидний, ламын жас урд явж байвал тэр ард явж байдаг, тийм. Ажил хийгээд л ажил хөдөлмөр янз бүрийн юу дуган шүтээн будах мудах болвол лам биднийг будаагүй байж болдоггүй тийм лам биднийг л харж хайрлаж явдаг байсан юм аа. Одоо ч бий, бид залбирч байдаг юмаа

Гантулга: Тэр лам нарын ламын жас хаахна байх уу, Чойрын хийдээс?

Ишсамбуу: Энүүхэнд нь байсан юм

Гантулга: Энүүхэнд нь баруун урд талд нь уу?

Ишсамбуу: Баруун урд талд нь

Гантулга: Ойрхон байсан уу?

Ишсамбуу: Ойролцоохон.

Гантулга: Хичнээн ламтай вэ, том жас байсан үү?

Ишсамбуу: Өө том жас, томоос том жас байсан. Зун л хурдаг байсан юм даа. Хайлантай тийм л газар байсан

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Гантулга: Их томдуу бурхантай ?

Ишсамбуу: Тийм, их том бурхантай. Тэгээд тэрэнд нь бид мөргөж үргэлж шүтэж байдаг

Гантулга: Өөр ямар ямар жасаар одоо ямар ямар жас дээр очиж хурж байсан бэ?

Ишсамбуу:Багийн жас гэж байсан. Цагаан арцны багад би нэг л очиж байсан даа.Бага байхад нэг бурхны шавь нарыг дагуулж очиж байсан даа.Би бас сайн мэдэхгүй л байна.Шинэ Булаг дээр бас очиж байсан.Бас байнга очиж байгаагүй

Гантулга: Дуган сүм олонтой газраг байсан уу?

Ишсамбуу: Өө байна.Цаана Чойр нь байгаагүй байх .Харин Чойрын цагаан ван тэр Манзшираар нь очиж байхад багын их хүнтэй очиж байсан шиг санагдах юм.Тийм л байсан юм даа. Майдар эргэдэг байсан

Гантулга: Зүүн Жанжин Чойрын гол шүтээн сахиус нь ямар бурхан байсан бэ?

Ишсамбуу: Дамдинчог байсан юм. Манай Зүүн Чойрын шүтээн нь Дамдинчог байсан юм

Гантулга: Лхам эрдэнэ нь?.

Гантулга: Гол шүтээн нь ?

Ишсамбуу: Гол шүтээн нь одоо...

Гантулга: Сахиус нь Дамдинчог байсан юм уу?

Ишсамбуу: Тийм

Гантулга: Аа гол шүтээн нь лхам эрдэнэ?

Ишсамбуу: Одоо тэр чинь хоёулаа л

Гантулга: Хоёулаа л гол шүтээн нь үү?

Ишсамбуу: Хоёулаа л шүтээн юм даа. Тэр Лхам эрдэнэ гэдэг чинь одоо...

Гантулга: Хэр олон байсан бэ, Зүүн Чойрт?

Ишсамбуу: Өө мянга таван зуу л гэж ярьдаг шуу даа

Гантулга: Лхам эрдэнэ бурхан бол лав түүхтэй байх даа

Ишсамбуу: Түүхтэй

Гантулга: Яаж ирсэн Чойрт, яагаад тэгж их шүтдэг байсан юм бэ?

Ишсамбуу: Аа тэр түүхтэй юм гэнэ лээ. Аа хөөрхий айхтар дураараа ер нь тэгээд хүүхдэд их сайн , хүүхдэд дуртай тэр ламын жас хороонд тэр хураад л байдаг,нэг айхтар том гэр барьчихсан л байдаг.Тэр гэр чинь үймээн цагаан гэдэг нэртэй , тэр гэрт л бужигнаж байдаг.Тийм , тэгээд хойш нь ч нэг харуулчихдаг, урагш нь ч нэг харуулчихдаг, тэнд бужигнаж л байсан юм. Тэгээд нэг мэдээ өгөөгүй юм гэнэ лээ.Тэр манай сан манж болох гэсэн манж нь ойшоодоггүй , манж нь дээшилдэггүй байжээ.Тэгээд ердөө одоо яадаг юм бол одоо манж нь ердөө дээш хардаггүй.Тэгээд энэ одоо яагаад байна вэ, яагаад байна вэ гэсэн, тэрүүгээр тэгээд их үджээ. Хүүш лам эрдэнэ мэдээ өгсөнгүй ээ.Лхам эрдэнэ чи надад өг, лам эрдэнэ жоохон охин доо.Тэгээд л мэдээ өгөх гээд урд нь очиж хайнга нэгж өгөөд гурав тэгээд тэрийг нь мартчихаж.Тэгээд өнөөхийг нь бичих гэхлээр тооно нь ч

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

тэр их айхтар давхар модон тагтай юу байдаг байж...Бахим тогоо.Өнөөхийг нь аваад шидэж байсан юм гэнэ лээ.За тэгээд тиймэрхүү юм бишгүй л болж байсан гэсэн

Гантулга: Энэ голдуу Боржигон Цэцэн хошууны хүмүүс ирж шавилж суудаг байсан уу?

Ишсамбуу: Тийм

Гантулга: Ер нь хутагт хувилгаан гэж байсан уу, Зүүн Чойрт?

Ишсамбуу: Гэгээн хутагт байлаа. Гэгээн хүмүүс байсан л байх. Чухам нэгтэй тэнцэх юм уу

Гантулга: Баруун Чойроос нэг хувилгаан ирсэн гэсэн үү?

Ишсамбуу: Аа тийм .Ловон лам

Гантулга: Баруун Чойрын ловон лам гэж...Хэн гэдэг хүн байсан юм?

Ишсамбуу: Мэдэхгүй

Гантулга: Том эрдэмтэн гавж, аграмб нар олон л байсан байх?

Ишсамбуу: Аа байсан байсан. Олон л байсан байх

Гантулга: Нэртэй зурхайч?

Ишсамбуу: Байлгүй

Гантулга: Дүйнхорын дацантай байсан гэж байгаа тиймээ?

Ишсамбуу: Тийм

Гантулга: Мамбын дацантай?

Ишсамбуу: Байсан.Мамба байсан.

Гантулга: Нэртэй том зураач, бурханч?

Ишсамбуу:Бурханч лам байсан юм гэнэ лээ

Гантулга: Та түрүүн хэлж байсан , тэр хамба лам нь тийм хүн байсан, эртний тийм хуучны улсууд бас нэрлэж байсан?

Ишсамбуу: Аа одоо би бас тэгээд нэрийг нь болохгүй л байна.За би бол одоо Чойрын дацанд л байсан

Гантулга: Гэсрийн дамжаа гэж...?

Ишсамбуу: Аа нэг хадаг хийдгээс гараагүй ээ, хадаг хийдэг л дамжаа байсан

Гантулга: Дацанд бол ороогүй юу?

Ишсамбуу: Ороогүй.

Гантулга: Чойрын хийд хичнээн дацан, жас сүм дугантай байсан бэ?

Ишсамбуу: Аа нэг дөрвөн том дацан, таван дацан байж дээ.Ганжуур жастай байсан юм.Ганжуур жасаа ч оруулаагүй байна. Тэгээд нөгөө ламын жасаа ч бас оруулаагүй байна.Зургаан жас байж дээ

Гантулга: Ганжуур жас , ламын жас, тэгээд дүйнхор, чойр?

Ишсамбуу: Жүд мамба дацан нь

Гантулга: Цогчин нь тэр ганжуур дотроо?

Ишсамбуу: Цогчин нь ганжуураас гадна байна

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Гантулга: Тэгээд одоо дацан бүр нь одоо чойрын дацан чойрынхоо номыг сургаад л?

Ишсамбуу: Тийм, тэгээд тус тусдаа

Гантулга: Жүд нь жүд ээ?

Ишсамбуу: Тийм л байх даа, одоо. Чойроос чинь гараад...Мамбынх чинь тусдаа хурал хурдаг.Тусгай, тэр дүйнхор, жүд дацан чинь мамбынхаа хоёр тийшээ байдаг юм

Гантулга: Мамба нь бол тийм биеэ даачихсан, ерөөсөө л тэрүүхэн тэндээ?

Ишсамбуу: Тийм. Аа цогчин болохлээр тоймоороо хурна.Их л том. Хаанаас ч байсан лам л бол ирж хурдаг

Гантулга: Зүүн Чойрын хийд олон суваргатай байсан уу?

Ишсамбуу: За нэг л том суваргатай байсныг мэдэж байна

Гантулга: Ном барладаг байсан болов уу?

Ишсамбуу: Одоо байсан л байх даа

Гантулга: Хурал тарах үед шинээр одоо сүүлд бол энэ сүм дуган дацангуудыг дахиж шинээр барьсан юм байна уу?

Ишсамбуу: Байгаагүй ээ, байгаагүй байх аа.Мэдэхгүй ээ

Гантулга: Цогчин уншлагаа бол тэр ганжуурын жасдаа хурчихдаг байсан юм уу?

Ишсамбуу:Тийм, зун нэг хурна, өвөл нэг хурна

Гантулга: Тэгээд тэр олон лам чинь цөм нийлээд л ?

Ишсамбуу: Тэгнэ

Гантулга: Мянга таван зуугаад лам нар?

Ишсамбуу: Ээ дээ мянга таван зуугаад...

Гантулга: Бүгд багтдаг байсан уу?

Ишсамбуу: Бүгд багтдаг байсан ш дээ.Том дацан байсан.Даавуугаар бүрээслэчихдэг

Гантулга: Цогчинд хурал хурахаараа ямар ном хурах вэ?

Ишсамбуу: Аа яахав дээ, тэгээд өнөөх ...Магтаал, Чойжий Догшид. Чойжий Догшидоосоо л уншина.Чойжий Догшид, тэгээд янз бүрийн л юм уншина .Өвлийнх нь Догшид хурна. Цагаан сар болтол тэгээд...

Гантулга: Зун нь?

Ишсамбуу: Зун цагт бүтээл хийнэ, маанийн тийм бүтээлтэй

Гантулга: Олон хоног уу?

Ишсамбуу:Олон хоног.Тэгээд янз бүрийн юм их хурж байсан

Гантулга: Тэгээд сарын одоо шинийн найман, дүйчэн өдрүүдийн хурал бас байсан уу?

Ишсамбуу: Ээ тийм, сарын хурал гэж байсан. Хурын хурал гэж байсан.

Гантулга: Цам гардаг байсан гэж байгаа биз?

Ишсамбуу:Цам гардаг байсан.

Гантулга: Том цамтай гардаг байсан уу?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ишсамбуу: Том цамтай гардаг байсан

Гантулга: Олон баг?

Ишсамбуу: Олон багтай

Гантулга: Цамынх нь аль аль дацангаас гардаг байсан ?

Ишсамбуу: Жүдээс

Гантулга: Жүдээс гардаг байсан уу?

Ишсамбуу: Хорин нэгэн дарь эхтэй тэр том цам

Гантулга: Майдар эргэх үү?

Ишсамбуу: Эргэнэ ээ

Гантулга: Олон хоног эргэх үү, нэг л өдөр эргэх үү?

Ишсамбуу: Өө нэг л өдөр эргэнэ

Гантулга: Цам нь бас нэг л өдөр гарах уу?

Ишсамбуу :Нэг билүү өдөр гардаг байсан

Гантулга: Майдар нь нөгөө ногоон морьтой майдраа залаад л ?

Ишсамбуу: Тэгнэ

Гантулга: Тэгээд л үдлээ...?

Ишсамбуу: Аан тийм

Гантулга: Олон лам?

Ишсамбуу: Олон бид нар бүгдээрээ л байсан. Хөдөөнөөс орж ирсэн гээд л их л сайхан юм болдог байсан даа. Одоо бага байхад.

Гантулга: Ганжуур эргэдэг байсан уу?

Ишсамбуу: Эргэнэ ээ эргэнэ

Гантулга: Лам нар өөрсдөө?

Ишсамбуу: Тэгнэ

Гантулга: Хошуу ганжуур эргэдэг байсан биз?

Ишсамбуу: Хошуу ганжуур эргэнэ

Гантулга: Эргэхдээ яаж эргэдэг байсан юм, тэр?

Ишсамбуу: Чойрын хошуу ганжуур , уулын ганжуур, хүрээ ганжуур гэж ийм гурван их ганжуур эргэдэг байсан юм. Тэрнийг нь очиж харж, тэгээд л их ном гуйхгүйгаар суманд хийж, тэмээнд ачаад л явдаг байсан .Хошуу ганжуур

Гантулга: Аан хошуу нутгаа тэгж...?

Ишсамбуу: Тийм .Тэгээд л их халуур ч явдаг байсан. Одоо улын ганжуур гэдэг чинь бас тэмээнд ачааллачихсан олон таван лам нар. Тэр уулыг ёстой л бага байхад тойрдог байсан юм байгаа юм. Тийм л юм, одоо тэгээд нэг

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

өдөрт багтаж байсан юм болов уу, одоо тэгээд бороо их асгардаг байсан юм. Ямар сайндаа л бороо орохлээр зэрэг энэ уулын өндөрлөг газар яадаг байсан юм

Гантулга: Нөгөө ганжуур нь ямар ганжуур гэнэ ээ? Уулын ганжуур өшөө ганжуур ?

Ишсамбуу: Уулын ганжуур өшөө ганжуур за байз нэг оройхон эргэдэг ганжуур...

Гантулга: Тэрийг нь юу гэж нэрлэх вэ?

Ишсамбуу: Тэрийг нь одоо ...Уулын ганжуур , Өшөө ганжуур, Чойрын ганжуур л гэж байсан юм даа. Тийм л ганжуур эргэж явдаг байсан юм

Гантулга: Их ганжуур эргэдэг байжээ?

Ишсамбуу: Тийм .Чойр чинь одоо их ганжуур эргэнэ. Зуун ганжуур хурна. Ганжуур хурахдаа их юм болно доо

Гантулга: Бурхан багш ,Богд ламын дүйчэн өдрүүдээр их хурал ном хурах уу?

Ишсамбуу: Ээ дээ .Их л ном хурдаг байсан юм

Гантулга: Ерөөл?

Ишсамбуу: Тийм

Гантулга: Цагаан сараар бас хуучдын хурал хурах уу?

Ишсамбуу: Хуучдын хурал яг л юм билээ дээ. Богдын хурал эд нар чинь чагнаж байхад одоо...

Гантулга: Зүүн Чойр чинь одоо энэ Баруун Зуугаас дэгтэй гэж байгаа биз дээ?

Ишсамбуу: Тэгж байгаа юм. Баруун Зуугийн энэ баруун газраас л дэгтэй юм

Гантулга: Баруун Чойр нь болохоор?

Ишсамбуу: Хүрэнээс

Гантулга: Хүрээ дэгтэй ?

Ишсамбуу: Хоёулаа бас дэг нь арай таардаггүй ондоо байсан юм

Гантулга: Ер нь бие биедээ очиж ном уншиж, хурал ном хурдаг байсан уу? Баруун , Зүүн Чойр?

Ишсамбуу: За ер нь мэдэхгүй ээ

Гантулга: Тэр ловон ламыг залдаг байсан гэсэн?

Ишсамбуу: Тийм. Тэгдэг байсан юм .Тэгээд л зална, асууж сурна, тэгээд л ловон лам чинь их мундаг хүн байж л дээ, жижиг хүн байж. Одоо урьд чинь нэрийг нь хэлдэггүй , тийм лам, ийм хамба л гэдэг байж дээ. Одоо бодоход нэр ус нь ямар ч нэртэй байсан юм , мэдэхгүй

Гантулга: Хайлан хурдаг байсан уу?

Ишсамбуу: Хайлан хурна

Гантулга: Айхтар хурах уу?

Ишсамбуу: Өө айхтар

Гантулга: Олон хоног хурах уу?

Ишсамбуу: Гэлэн нь одоо олон хоногийн хайлантай...

Гантулга: Нүгнээ тахидаг байсан уу?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ишсамбуу:Тахина аа

Гантулга: Одоо энэ Чойрын дацан, Мамбын дацан гээд дацангууд одоо тусдаа өдөр бүрийн хурал одоо дүйчэн өдрөөр ч юм уу?

Ишсамбуу: Дацангууд бол одоо тус тусдаа хурдаг.

Гантулга: Одоо таны хурж байсан Чойр дацан бол одоо өдрийн хуралдаа яадаг байсан. Ямар ямар ном унших уу?

Ишсамбуу: Одоо нөгөө нэг юу...уншлаганыхаа номнуудыг л уншина даа

Гантулга: Цогчинд уншдаг номнуудаа юу?

Ишсамбуу: Аа тэр Чойрын хурал гэж бас ондоо байсан.

Гантулга: Бас ондоо байсан уу?

Ишсамбуу: Ондоо ондоо.Одоо өнөөх Зүйлэн хурлын ном гэж яахав дээ.Бас хэлэх гэхээр болохгүй байна аа

Гантулга: Чойрын дацанд өөр одоо додм барих гээд арай өөр?

Ишсамбуу: Байна аа

Гантулга: Нөгөөдүүлээсээ ондоо арай өөр тийм яшз бүрийн шашны зан үйл?

Ишсамбуу: Домын хурал гэж нэг жил болоод л дом тавьдаг байсан юм. Тэр домын зиндааныхан жил болохлээрээ л домоо хурдаг.

Гантулга: Гавжийн дамжаа , аграмбын дамжаа гэж байсан уу?

Ишсамбуу: Байсан. Барьдаг байсан, гавжийн дамжаа, аграмбын дамжаа барьдаг байсан

Гантулга: Энэ дамжааг олон хүн барих уу, нэг дамжаа барихад олон хүн барилцах уу?

Ишсамбуу: Хоёр гурван хүн л барьдаг байсан байх

Гантулга: Олон хоног барих уу?

Ишсамбуу: Өө гурав дөрвөн хоног байдаг байсан байлгүй дээ

Гантулга: Энэ дуган дацангууд нь голдуу тоосгоор барьсан байсан уу, модоор уу, эсгий...?

Ишсамбуу: Мод. Модон жас байсан байх

Гантулга: Ганжуурын жас нь?

Ишсамбуу: Мод оо мод .

Гантулга: Чойрын дацан нь ?

Ишсамбуу: Мод байсан. Модон л байсан байх даа.Ганц нэг ...

Гантулга: Гал зуух эд нар нь бол тоосго байсан уу?

Ишсамбуу: Тийм

Гантулга:Тэр Баруун Зуугийн гэхээрээ одоо?

Ишсамбуу: Ихээхэн чанга дэгтэй л байж дээ.Айхтар чанга дэгтэй байсан юм гэнэ лээ.Ямар сайндаа л Баруун Чойрын хүрээ дэгтэй таардаггүй байсан юм гэнэ лээ

Гантулга: Лам нар нь хаагуураа амьдрах вэ, хийдийнхээ?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ишсамбуу: Тэр дотуураа л одоо гэр байшинтайгаа амьдарна даа

Гантулга: Дуган сүм нар нь бол өмнүүрээ?

Ишсамбуу: Өмнүүрээ л голцуу

Гантулга : Тэгээд араар нь юмуу, зүүн баруунаар нь ?

Ишсамбуу: Тийм

Гантулга: Лам нар нь гэрт голцуу?

Ишсамбуу: Гэрт голцуу

Гантулга: Байшин саванд байсан уу?

Ишсамбуу: Өвөл болохоор гэрт, зун болохоор байшинд орно

Гантулга: Модон байшин?

Ишсамбуу: Модон байшин.Гэр бол байлгадаггүй.Газар нь тийм юм уу, бас хад асга ихтэй газар байсан юм

Гантулга: Зоч лүйжин гэж байсан уу?

Ишсамбуу: За байсан юм гэнэ лээ. Хадаад явж юу яадаг байсан , бас энүүхэндээ яадаг байсан юм гэнэ лээ.Хадаад л явдаг байсан юм гэнэ лээ

Гантулга:Марзын хад уу?

Ишсамбуу: Үгүй ээ, тэр уулынхаа хаданд. Тийм юм байсан гэнэ лээ

Гантулга:Та бол одоо тусгайдаа биеэ дааж амьдардаг байсан уу, багшийндаа амьдардаг байсан уу?

Ишсамбуу: Багшийндаа амьдардаг байсан

Гантулга: Ер нь өглөө босоод орой унтах хүртлээ юу хийх вэ одоо, нэг өдрийнхөө юуг яривал?

Ишсамбуу:/инээв/

Гантулга: За өглөө бослоо...?

Ишсамбуу: Одоо энэ тэгээд л ажлаа хийгээд л , ажил ч юу байхав дээ. Тэгээд л хурал хурвал хуралд суугаад л .Тэгээд тэгс хийгээд л

Гантулга: Борчуулын хороолол гэж байсан уу, хар ажил хийдэг тийм лам биш борчуул?

Ишсамбуу: Өө байсан л юм байна.

Гантулга: Түлээ мүлээ ус зөөдөг, өөр тийм гарын дүйтэй урчууд?

Ишсамбуу: Байсан л байлгүй дээ

Гантулга: Ойрхон худалдаа наймааны тийм газар байсан уу?

Ишсамбуу: За тийм ч их юм байгаагүй байх аа.

Гантулга: Цөөвтөрхөн?

Ишсамбуу: Цөөвтөрхөн байсан л байх.Талх малх хийж сурдаг л байсан юм

Гантулга: Хятадын наймаа байсан уу?

Ишсамбуу: Тийм юм байгаагүй ээ

Гантулга: Тэр Чойрын хурал тарна гэж сургуульд аваад явсан.Тэгээд л тарчихсан юмуу?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ишсамбуу: Тэгээд одоо бодоход есөн сар арай хүрээгүй байхад аваад явж дээ.Тэгээд л тэр чинь тэгээд арван нэгэн сар зулын хорин таван чинь хэдэн билээ дээ.Тэрнээс хойш удахгүй шүү дээ , өвөл.Тэгэхэд л бариад хоморголоод тэгээд л үймчихсэн юм

Гантулга: Тэгэхэд та нар сургууль руу явчихсан байсан уу?

Ишсамбуу: Явчихсан байсан.гурван хийдийн хүүхдүүд, манай Зүүн Чойр, баруун Чойр , Мөнгөн морьтын гурван хийдийн хүүхэд явж очиж байсан юм.Тэгээд одоо Майн нэгэн өнгөрөөгөөд л хичээл тардаг байсан юм

Гантулга: Одоо энэ сум аймгаас бол ямар хүмүүс ирээд одоо сүм хийдийг хаах ч гэдэг юмуу очсон улсуудыг та санаж байна уу?

Ишсамбуу: Аа мэдэхгүй нэг хэдэн хүн их л ирдэг байсан байх .Сайн мэдэхгүй , голдуу л засаг захиргаанаас Хайнчиг гэж нэг хүн байсан .Тэр л их ирдэг байсан

Гантулга: Тэр таныг яваад Маань нэгнээс хойш ирэхэд чинь сүм дуган нь байсан уу?

Ишсамбуу:Байсан байсан.Тэр сүм дуган нь ч сайан байсан. Харин хурлаа хаачихсан.Яагаад гэхлээр нөгөө юмаа битүүлээд хурлаа хаачихсан.

Гантулга: Тэгээд түр сүм хэр удаан байсан, хаашаа алга болчихсон юм бол?

Ишсамбуу: Хэн мэдэхэв, тэр тэгээд л бид хөдөө л арилсан. Тэгээд суурь нь харагдаж л байсан. Аваад л яваа биз

Гантулга: Бурхан ном шүтээнийг нь тэгсэн ингэсэн гэж дүүлаагүй юу?

Ишсамбуу: Үгүй одоо яагаад хураачихсан юм, өөрсдөө л мэдсэн байх даа. Зарим нь шатсан л байх даа

Гантулга: Ийш тийшээ хот руу, одоо Гандан эд нар луу явсан юм болов уу?

Ишсамбуу: Ээ мэдэхгүй

Гантулга: Та чинь ерөөсөө хотод нэг жил сургуульд сурчихаад тэгээд хөдөө очсон юм уу?

Ишсамбуу: Тэгээд ирээд амжсан.

Гантулга: Тэгээд ахиж очоогүй.

Ишсамбуу: Ахиж очоогүй

Гантулга: Шууд малчин болсон?

Ишсамбуу:Олон улс олон хүүхэд зарим нь ахиж очоогүй, зарим нь очсон.Очсон нэг нь энэ юугаа дагаад явсан

Гантулга: Номоо дагаад?

Ишсамбуу: Биднүүс ч яахав нэг хөндийхөн байсан.Тэгээд малчин болоод...

Гантулга: Ирээд та нэгдэлд мал маллаад ...?

Ишсамбуу: Тийм, малчин л байсан

Гантулга: Ерэн онд энэ Чойрын хурал сэргэсэн гэж байгаа ш дээ?

Ишсамбуу: Тэгсэн

Гантулга: Тэгэхэд та очиж ном хурж...?

Ишсамбуу: Хураагүй.Тэгээд би нэг малаа дөхүүлээд л , за яахав яахав гээд хураагүй

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Гантулга: Лам байсан, гайгүй номтой байсан улсуудтайгаа хааяа уулзаж ном момоо сэргээж ярих тийм юм байх уу?

Ишсамбуу: Байхгүй.Тэр зун л очдог байсан юм

Гантулга:Үгүй ээ үгүй, тэр ерэн оноос өмнө социализмын үед та бас хааяа номоо сэргээж.../инээв/?

Ишсамбуу: Үгүй одоо тийм юм байгаагүй байх аа байгаагүй байх

Гантулга: Одоо сэргээгдээд өдөр бүрийн лам нар хурж байна уу, ламтай байгаа юу, ламгүй байгаа юу?

Ишсамбуу: Цөөхөн ламтай л юм гэнэ лээ

Гантулга: Аа ламтай байгаа юу?

Ишсамбуу: Цөөхөөн юм байна лээ.Бараг нь л байхгүй болсон.Зарим нь малтайчууд нь яваад өгсөн

Гантулга: Ерэн онд сэргэхэд хэр...?

Ишсамбуу: Олон хүн байсан юм.Дөч тавиад хүн байсан байгаа юм.Хүүхэд мүүхэд чиг л байсан .Зарим нь шилжээд явчихсан шиг байна лээ

Гантулга: Гол санаачилсан гурван хүн нь та нэг үнзад байсан гээд , гэсгүй, даа лам билүү ловон лам билүү...?

Ишсамбуу:Галсан...Галсанжамц.За даа тэгээд тийм л байна даа.

Гантулга: Чойрын хийдийн тухай сайхан ярилцлага өгсөн таньд баярлалаа.

Ишсамбуу: За тэгээд хойчдоо сайн явах болтугай.

Гантулга: За баярлалаа

Ишсамбуу: За баярлалаа.